


БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ, ЗАСАГЛАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Энэхүү тайлан нь Монголын Хөрөнгийн Биржид бүртгэлтэй компаниудын байгаль орчин, нийгэм, засаглал (БОНЗ)-ын чиглэлээр тайлант хугацаанд авч хэрэгжүүлсэн стратеги, арга хэмжээ, нөхцөл байдлыг хөрөнгө оруулагчид, хувьцаа эзэмшигчид, олон нийтэд ил тод нээлттэй тайлагнах зорилготой.

Хэсэг 1, 2, 3 нь нийт үнэт цаас гаргагч компаниудад хамааралтай бөгөөд Хэсэг 4 нь зөвхөн тухайн салбарт үйл ажиллагаа явуулж буй үнэт цаас гаргагчдад хамаарна.

Хэрэв тайлангийн маягтад заасан аливаа мэдээллийг цуглуулах, тайлагнах боломжгүй бол тайлагнах боломжтой талаарх тайлбар, цаашид мэдээллийг тайлагнах чиглэлд авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар 'тайлбар' хэсэгт бичнэ үү.

Огноо (он, сар, өдөр):	3/4/2024
Үнэт цаас гаргагчийн нэр:	ГОВЬ ХК
Үнэт цаасны нэр, код (МХБ симбол):	GOV
Салбарын ангилал:	Үйлдвэрлэл
Тайланд орсон компаниуд (энэхүү тайланд орсон толгой болон охин компаниудын мэдээлэл):	
Тайлангийн хамрах хугацаа:	2023.01.01-2023.12.31
Хариуцсан албан тушаалтны овог нэр, албан тушаал, холбоо барих имэйл хаяг, утас:	Э.Ивгээл, Тогтвортой хөгжлийн хэлтсийн дарга, headsustainable@gobi.mn
Тайланг баталгаажуулсан гүйцэтгэх удирдлагын мэдээлэл (нэр, албан тушаал):	Б.Амарсайхан, Гүйцэтгэх захирал
Гүйцэтгэх удирдлага эсвэл ТУЗ-ийн даргын гарын үсэг:	

#	Бүлэг	Шалгуур үзүүлэлт	Үзүүлэлт (тайлант он)	Хэмжих нэгж	Нэмэлт мэдээлэл	Тайлбар	Холбоос	
Тогтвортой хөгжлийн удирдлагын системтэй холбоотой шалгуур үзүүлэлтүүд								
MS1.1	Тогтвортой хөгжлийн удирдлагын систем	Удирдлагын амлалт	Удирдлагаас баталсан тогтвортой хөгжлийн амлалт/мэдэгдэл байдаг эсэх	Тийм	1.Тийм 2.Үгүй https://info.gobi.mn/policy 2022 онд ТУЗ-өөс "Тогтвортой хөгжлийн үүрэг амлалт"-ыг баталсан. Уг үүрэг амлалтад цаашид тогтвортой хөгжлийн үйл ажиллагааг бизнесийн үйл ажиллагаандаа нэгтгэн тасралтгүй хөгжүүлж, байгаль орчин, нийгэм, засаглал, ноолуурын салбарын хүрээнд хэрхэн ажиллах тухайгаа амлалт байдлаар тусгасан бөгөөд компанийн хэмжээнд шат дараатайгаар төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг нь ханган ажиллаж байна.		GRI 102	
MS2.1		Тогтвортой хөгжлийн бодлого, зохицуулалт	Тогтвортой хөгжлийн бодлого, зорилтуудыг тодорхойлж баталсан эсэх	Тийм	1.Тийм 2.Үгүй https://info.gobi.mn/policy 2022.07.22-ны өдрөөс Тогтвортой хөгжлийн бодлогыг баталж, 2025 он хүртэлх зорилтуудыг тодорхойлон тусгасан.		GRI 103, ISO 14001	
MS2.2		Бүтэц удирдлага	Танай компанид тогтвортой хөгжлийн асуудал хариуцсан хороо байдаг эсэх	Үгүй	1.Тийм 2.Үгүй Тогтвортой хөгжлийн хороо байхгүй ч ТУЗ-ийн хэмжээнд тогтвортой хөгжлийн асуудалд тогтмол анхаарал хандуулж, жилд 2 удаа ТУЗ-ийн ээлжит хурлаар БОНЗ-ын үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлантай танилцан хэлэлцэж, заавар чиглүүлгээр ханган ажиллаж байна. Мөн Гүйцэтгэх удирдлагын зүгээс БОНЗ-ын үйл ажиллагааны чиглэлээр төлөвлөсөн ажлуудыг шат дараатай хэрэгжүүлэхэд шаардлагатай төсөв санхүүжилтийг шийдвэрлэн дэмжин ажилладаг.		GRI 103, ISO 14001	
MS3.1			ТУЗ-ийн түвшинд тогтвортой хөгжил / БОНЗ-ын асуудал хариуцсан гишүүн (бүтэн цагийн/хавсран) байдаг эсэх	Үгүй	1.Тийм 2.Үгүй Тогтвортой хөгжил хариуцсан ТУЗ-ийн гишүүн байхгүй бөгөөд компанийн хэмжээнд тогтвортой хөгжлийн үйл ажиллагаа жигдрэх хүртэл бүх гишүүд хамтран анхаарал хандуулж ажиллаж байна. Энэ хүрээнд ТУЗ-ийн хараат бус гишүүд 2022 онд БОНЗ-ын чиглэлээр сургалтад хамрагдаж нэгдсэн мэдлэг ойлголттой болсон бөгөөд 2023 онд Европ руу томиллолтоор явж тогтвортой хөгжлийн чиглэлээр үйлдвэр, компаниудаас туршлага судалж компанийн хэмжээнд хэрэгжүүлэх төслүүдийг санаачлан ажилласан.		GRI 102	
MS3.2			Гүйцэтгэх удирдлагын түвшинд тогтвортой хөгжил/ БОНЗ-ын асуудал хариуцсан албан тушаалтан (бүтэн цагийн/хавсран) байдаг эсэх	Тийм	1.Тийм 2.Үгүй Стратеги, Өсөлт хөгжил хариуцсан захирлын удирдлагад Тогтвортой хөгжлийн хэлтэс ажилладаг бөгөөд уг хэлтэс нь компанийн тогтвортой хөгжлийн цаашдын бодлого, зорилго, зорилтуудыг тодорхойлон хэрэгжүүлж гүйцэтгэлийн үр дүнг оролцогч болон сонирхогч талуудад тайлагнаж, үйл ажиллагааны тасралтгүй байдлыг сайжруулан ажиллаж байна.		GRI 102	
MS3.3			Үйл ажиллагааны түвшинд тогтвортой хөгжил/ БОНЗ-ын асуудал хариуцсан албан тушаалтан (бүтэн цагийн/хавсран) байдаг эсэх	Тийм	1.Тийм 2.Үгүй Үйл ажиллагааны түвшинд Тогтвортой хөгжлийн хэлтэст 10 орон тоо бүхий баг ажиллаж байна. Тус хэлтэс нь: Тогтвортой хөгжлийн удирдлага, Удирдлагын тогтолцоо, Комплаенс, Эрсдэлийн удирдлага, Байгаль орчны менежмент, Химийн бодис, хог хаягдал, Эрчим хүч, усны менежментийн хүрээнд компанийн одоогийн төлөв байдлыг тодорхойлж, богино-дунд-урт хугацааны зорилго, зорилтуудыг боловсруулан, хэрэгжүүлтийг ханган ажиллаж байна.		GRI 102	
MS3.4		Танай компани ТУЗ-ийн хурлын хөтөлбөрт тогтвортой хөгжлийн асуудлыг албан ёсоор тусгадаг уу?	Тийм	1.Тийм 2.Үгүй 2022 оноос эхлэн ТУЗ-ийн ээлжит хурлаар 1 хурал өнжөөд тогтмол Тогтвортой хөгжлийн асуудлыг тусган, хэлэлцэн ажиллаж байна. Хурлын үр дүнг жилийн үйл ажиллагааны тайланд тусгадаг.		GRI 102		
MS3.5		Тогтвортой байдлын нөлөөллийн үнэлгээ	Танай компани эдийн засаг, байгаль орчин, нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөллөөс хэрхэн зайлсхийх, бууруулах, арилгах, эерэг үр нөлөөг сайжруулах талаар тайлбарласан нөлөөллийн үнэлгээ эсвэл матриц байдаг эсэх	Үгүй	1.Тийм 2.Үгүй Байхгүй.	Эдийн засаг, байгаль орчин, нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөллөөс зайлсхийх, бууруулах, арилгах, эерэг үр нөлөөг сайжруулах зорилтуудыг компанийн Тогтвортой хөгжлийн бодлогод дэвшүүлэн зорилтуудад хүлээ үйл ажиллагааг тасралтгүй эрхэлж үйл ажилладаг.	SASB	
MS4.1		Чадавч бүрдүүлэлт	Нэг ажилтанд ногдох тогтвортой хөгжлийн тухай сургалтын жилийн дундаж цаг, хүйсээр	1.7 хүн/цаг	цаг	Тогтвортой хөгжлийн хэлтсээс 2023 онд давхардсан тоогоор 2115 ажилтанд нийт 2986.5 хүн/цагийн сургалт орсон байна. Нэг ажилтанд ногдох жилийн дундаж сургалтын цаг: 1.7 хүн/цаг.		GRI 102
MS4.2		Хяналт	Тогтвортой байдлын асуудал нь аудитын хорооны үйл ажиллагаа, дотоод хяналтын чиг үүрэгт хамаардаг уу?	Үгүй	1.Тийм 2.Үгүй Үгүй.		GRI 102, SDG 12	
MS4.3	Тогтвортой байдлын тайлагнал	1.7.1 Тогтвортой хөгжлийн тайлан (жилийн тайланд нэгтгэдэг эсвэл тусдаа тайлан)-гаа жилд нэгээс доошгүй удаа тайлагнадаг уу?	Тийм	1.Тийм 2.Үгүй 2021 оноос Тогтвортой хөгжлийн хэлтэсээс "Тогтвортой хөгжлийн тайлан"-г жилд нэг удаа оролцогч талуудад тайлагнаж байна.		GRI 102, SDG 12		
MS5.1	Танай компани олон улсын уур амьсгалын эрсдэлийн стандартын дагуу тайлагнадаг уу?	Үгүй	1.Тийм 2.Үгүй Үгүй.			GRI 102, SDG 12		

MS5.3	Гийшүүнчлэл, хамтын ажиллагаа	Танай компани тогтвортой хөгжлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг олон улсын болон дотоодын холбоо, нэгдэлтэй нэгдэж хамтран ажилладаг уу?	Тийм	1.Тийм 2.Үгүй	1. Үйлдвэрлэл-Малчин-Шинжлэх ухаан хоорондын уялдаа холбоог бэхжүүлж малын эрүүл мэнд, арчилгаа, маллагаа, үржил селекцийн ажлыг шинжлэх ухааны үндэслэлтэй хийж гүйцэтгэх, малчдад ямааны ноолуур бэлтгэлийн технологийн зөв дадал эзэмшүүлэх замаар ноолууран түүхий эдийн чанарыг сайжруулах, малчин өрхийн орлогыг нэмэгдүүлэх зорилготой "Тогтвортой ноолуур, гурван талт хамтарсан төсөл"-ийг Хөдөө аж ахуйн их сургууль, Малчид болон "Говь" ХК хамтран 3 дахь жилдээ хэрэгжүүлж байна. 2. Тогтвортой Ноос Ноолуурын Эвсэл /Sustainable Fibre Alliance/-ын гишүүн байгууллага юм. 3. НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр (UNDP)-тэй хамтран ажилладаг. 2023 оны 11 сард НҮБХХ дэргэдэх Монголын Тогтвортой Ноолуурын Платформ болон Уур амьсгалын Ногоон Сангийн санхүүжилтээр БОАЖЯ, ХХААХҮЯ-ийн хэрэгжүүлж буй "Монгол орны хөдөөгийн иргэдийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадамж болон эрсдэлийн менежментийг боловсронгуй болгох нь" (АДАПТ) төсөл хамтран зохион байгуулсан "Тогтвортой ноолуурын өдөр – 2023"-т ГОВЬ ХК нь "Усны зохистой хэрэглээг нэвтрүүлсэн шилдэг байгууллага" шагналыг хүртсэн. 2024 онд төсөл хөтөлбөр хамтран хэрэгжүүлэхээр төлөвлөж байна. 4. НҮБ-ын Үйлдвэр хөгжлийн байгууллага (UNIDO)-тай хамтран ажилладаг. Уг байгууллагын хэрэгжүүлж буй экспортыг дэмжих төсөлд хамрагдан ажиллаж байна. 5. Stepecolab төсөлд хамрагдсан 17 байгууллагын нэг юм. 2024-2025 онд шинэ төслүүд дээр хамтран ажиллахаар төлөвлөж байна. 6. Тогтвортой ноолуурын гинжин хэлхээг бий болгохоор ажиллаж буй AVSF Mongolia олон улсын байгууллагатай хамтран ажилладаг бөгөөд 2024 онд хамтын ажиллагаагаа өргөжүүлэхээр төлөвлөж байна.	GRI 102, SDG 17		
MS6.1 Байгаль орчны шалгуур үзүүлэлтүүд								
E1.1	Нийт эрчим хүчний хэрэглээ	Эрчим хүчний нийт зарцуулалтын хэмжээ болон зардал	33.2 сая кВт.ц 3,403,852,518.69 төг	Мега Втц '000	УБЦТС, ТЭЦ 3-ийн төвийн шугамнаас нийт эрчим хүчний эх үүсвэрийг авдаг. 2023 онд нийт 33.2 сая кВт.ц эрчим хүч хэрэглэсэн. Эрчим хүчний хэрэглээний зардал 3,403,852,518.69 төг	Эрчим хүч хэмнэлтийн арга хэмжээний үр дүнд 2023 онд нээж бүтээгдэхүүнд ногдох эрчим хүчний хэрэглээ нь 2022 онтой харьцуулвал 15.2% буурсан.	GRI 302, SDG 12	
E1.2	Цахилгаан	Цахилгааны нийт зарцуулалтын хэмжээ болон хэмнэлт (жилээр)	10.1 сая кВт.ц	Мега Втц '000	2023 онд нийт 10.1 сая кВт цахилгаан эрчим хүч зарцуулсан. Говь үйлдвэр-8.7 сая кВт Гоёо үйлдвэр-1.4 сая кВт		GRI 302, SDG 12	
E1.3	Эрчим хүч	Дулаан	Дулааны нийт зарцуулалтын хэмжээ болон хэмнэлт (жилээр)	23.4 мянган Гдж 59.2 мянган Гдж	ВТУ & % Гкал	2023 онд нийт 23.4 мянган ГДЖ дулааны эрчим хүч зарцуулсан. Говь үйлдвэр-21.2 мянган ГДЖ Гоёо үйлдвэр-2.2 мянган ГДЖ 2023 онд нийт 59.2 мянган ГДЖ уурын эрчим хүч зарцуулсан. Говь үйлдвэр-51.6 мянган ГДЖ Гоёо үйлдвэр-7.6 мянган ГДЖ	GRI 302, SDG 12	
E1.4	Түлш	Түлшний нийт зарцуулалтын хэмжээ болон хэмнэлт (жилээр)	65226 литр	Литр/кг & % ГЖоуль, Төгрөг	Дизель түлш, бинзений зарцуулалтын хэмжээ 65,226 литр.		GRI 302, SDG 12	
E1.5	Хүрэн эрчим хүч	СЭХ-ээс бусад эх үүсвэрээс авсан эрчим хүчний хэрэглээний хувь	0%	%	Манай байгууллага төвийн шугамд холбогдсон бөгөөд үйлдвэрийн байранд хүрэн эрчим хүч хэрэглэдэггүй.		SFRD	
E1.6	Сэргээгдэх эрчим хүч	СЭХ үүсвэрээс гаргаж авсан эрчим хүчний хэрэглээний хувь	0.51%	%	Үйлдвэрийн гадна талбай авто замын нарны цахилгаан үүсгүүр бүхий гэрэлтүүлэг нь 2023 онд 51.8 мян.квт нарны эрчим хүч ашигласан нь нийт хэрэглээний 0.51% болж байна.		GRI 302, SDG 7	
E2.1	Хүлэмжийн хийн ялгарал	3.1 Хүлэмжийн хийн ялгаруулалт	Компанийн шууд ба шууд бус үйл ажиллагаанаас ялгарсан нийт хүлэмжийн хийн дүн	24,664,918 тонн CO2	CO2/тонн	2023 онд байгууллагын шууд бус үйл ажиллагаанаас ялгарсан буюу цахилгаан, дулааны эрчим хүчний хэрэглээнээс ялгарсан хүлэмжийн хийн хэмжээ 24,664,918 тн CO2, байгууллагын үйл ажиллагаанаас гарсан ахуйн хог хаягдлаас 79.32 тн CO2 тус тус ялгаруулсан байна.	ЭХЗХ, Номадик Нью Энержи ХХК-ын хамтран боловсруулсан "Эрчим хүчний салбарын хүлэмжийн хийн ялгарлыг хэмжих, тайлагнах, баталгаажуулах аргаачлал"-ын дагуу тооцов.	GRI 305, SDG 13, WRI/WBCSD GHG protocol.
E2.2	Хүлэмжийн хийн ялгарал	3.2 Бууруулсан хүлэмжийн хий	Байгууллагын шууд ба шууд бус үйл ажиллагаанаас ялгарсан хүлэмжийн хийн нийт дүн (жилээр)	1,108,684 тонн CO2	CO2/тонн	Эрчим хүчний хэмнэлттэй инвертер болон компенсацилах төхөөрөмжүүдийг суурилуулах арга хэмжээг авч хэрэгжүүлснээр 2023 онд 1,072,684 тн CO2, дахин боловсруулах хаягдлыг хог дахин боловсруулах хаягдлын цэгт шилжүүлснээр 36 тн CO2 хүлэмжийн хийг бууруулсан	ЭХЗХ, Номадик Нью Энержи ХХК-ын хамтран боловсруулсан "Эрчим хүчний салбарын хүлэмжийн хийн ялгарлыг хэмжих, тайлагнах, баталгаажуулах аргаачлал"-ын дагуу тооцов.	GRI 305, SDG 13, WRI/WBCSD GHG protocol.
E2.3	Хүлэмжийн хийн ялгарал	3.3 Дүйцүүлэх арга хэмжээ /Карбон офсет/	Нийт карбон офсет буюу дүйцүүлэх арга хэмжээний (мод тарих хөтөлбөр, эсвэл хүлэмжийн хийг бууруулах гадны төслийг дэмжих гэх мэт)бууралт	29,200 тонн CO2	CO2/тонн	2023 онд дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний хүрээнд 200 ширхэг улиас болон шинэс мод, нөхөн сэргээлт, тохижилтын ажлын хүрээнд байгууллагын дотор болон гадаа талбайд 3000 ширхэг хайлаас моддыг шинээр тарьснаар жилд 29,200 тн CO2-г агаар мандлаас шингээв.	ЭХЗХ, Номадик Нью Энержи ХХК-ын хамтран боловсруулсан "Эрчим хүчний салбарын хүлэмжийн хийн ялгарлыг хэмжих, тайлагнах, баталгаажуулах аргаачлал"-ын дагуу тооцов.	GRI 305, SDG 13, WRI/WBCSD GHG protocol.
E3.1	Уур амьсгалын өөрчлөлт	Уур амьсгалын бодлого, журам	Танай компани уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг тусдаа эсвэл бусад журамд тусгасан бодлоготой юу?	Тийм	1.Тийм 2.Үгүй	2022 оны 7 сард батлагдсан Тогтвортой хөгжлийн бодлогод Байгаль орчны бодлого зорилгыг тодорхойлсон байдгаас гадна Уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг: Дэлхийн дулаарал, цөлжилт, ургамлын талхлагдал, усны хомсдол, хүлэмжийн хийн ялгаруулалт зэрэг сөрөг нөлөөллийг бууруулж, урьдчилан сэргийлэх зорилгоор бэлчээрийн тогтвортой байдлыг дэмжих, мод тарих, ус болон эрчим хүчний хариуцлагатай хэрэглээг нэмэгдүүлэх зэрэг хариу арга хэмжээг аван, бизнесийн үйл ажиллагаанд нийцүүлнэ гэж тусгасан байдаг.		GRI 201, TCFD, SDG 13
E3.2	Уур амьсгалын өөрчлөлт	Уур амьсгалын эрсдэл ба боломжийн үнэлгээ	Танай компани уур амьсгалын эрсдэл, боломжийн талаарх үнэлгээ хийсэн үү?(сценарийн шинжилгээ, стресс тест гэх мэт)	Үгүй	1.Тийм 2.Үгүй	Үгүй.		GRI 201, TCFD, SDG 13
E3.3	Уур амьсгалын өөрчлөлт	Эдийн засгийн хохирол	Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй гамшиг, үйл явдлын улмаас учирсан эдийн засгийн нийт хохирлын хэмжээ	Хэмжих боломжгүй	Төгрөг	Хэмжих боломжгүй.		GRI 201, TCFD, SDG 13
E3.4	Уур амьсгалын өөрчлөлт	Уур амьсгалын хөрөнгө оруулалт	Уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг дэд бүтэц, дасан зохицол, бүтээгдэхүүн хөгжилд оруулсан нийт хөрөнгө оруулалтын дүн	100,672,450 Төгрөг	Төгрөг	Эрчим хүч хэмнэлт 2023 онд эрчим хүч хэмнэлтийн ажлын төлөвлөгөө батлуулж, эрчим хүчний өндөр хэрэглээтэй агааржуулалтын төхөөрөмжүүдэд инвертер суурилуулах ажлыг хийж гүйцэтгэсэн. Эрмэлзийн үйлдвэрийн агааржуулалт, нэхмэлийн үйлдвэрийн агааржуулалт, будах үйлдвэрийн агааржуулалтыг инвертержүүлэхэд 100,672,450₮ зарцуулсан. Инвертер суурилуулсанаар нийт цахилгаан хэрэглээний 2.3%-ийг хэмнэсэн.		GRI 201, TCFD, SDG 13

E3.4		Уур амьсгалын хөрөнгө оруулалт	Уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг дэд бүтэц, дасан зохицол, бүтээгдэхүүн хөгжилд оруулсан нийт хөрөнгө оруулалтын дүн	100,672,450 Төгрөг	Төгрөг	Эрчим хүч хэмнэлт 2023 онд эрчим хүч хэмнэлтийн ажлын төлөвлөгөө батлуулж, эрчим хүчний өндөр хэрэглээтэй агааржуулалтын төхөөрөмжүүдэд инвертер суурилуулах ажлыг хийж гүйцэтгэсэн. Ээрмэлийн үйлдвэрийн агааржуулалт, нэхмэлийн үйлдвэрийн агааржуулалт, будаа үйлдвэрийн агааржуулалтыг инвертержүүлэхэд 100,672,450₮ зарцуулсан. Инвертер суурилуулсанаар нийт цахилгаан хэрэглээний 2.3%-ийг хэмнэсэн.		GRI 201, TCFD, SDG 13	
E3.5		Уур амьсгалын өөрчлөлтөөс урьдчилан сэргийлэх эсвэл дасан зохицох	Уур амьсгалын өөрчлөлттэй холбоотойгоор танай компанийн ашигт ажиллагаа эсвэл бүтээгдэхүүн, үйлчилгээний чанарт нөлөөлөх эрсдэлээс урьдчилан сэргийлэх, (хэрэв урьдчилан сэргийлэх боломжгүй бол) дасан зохицох чиглэлд хэрэгжүүлэх арга хэмжээ/алхмуудыг тодорхойлсон уу?	Үгүй	1.Тийм 2.Үгүй	Үгүй.		GRI, SASB, World Economic Forum	
E4.1	Ус	Усны хэрэглээ	Ашигласан усны нийт хэмжээ	142 мян.м3 618,500,000 төгрөг	м3/Л	2023 онд нийт 142 мян м3 ус хэрэглэсэн. /Сард дунджаар 11.8 мян.м3/ Усны төлбөрт 618.5 сая төгрөг төлсөн.		GRI 303, SDG 6	
E4.2		Хэмнэсэн ус	Хэмнэлт, үр ашгийг дээшлүүлснээр нийт хэмнэсэн/дахин боловсруулсан усны хэмжээ	3.1 мян.м3	м3/Л	Агааржуулалтын хөргөлтийн усыг анхан шатны угаах үйлдвэрт дахин ашигладаг бөгөөд 2023 онд 3.1 мян.м3 усыг дахин ашигласан.		GRI 303, SDG 6	
E4.3		Дахин боловсруулсан ус	Дахин ашигласан болон боловсруулсан усны эзлэх хувь	2.20%	%	Агааржуулалтын хөргөлтийн усыг анхан шатны угаах үйлдвэрт дахин ашигласан нь нийт усны хэрэглээний 2.2% болж байна.		GRI 303, SDG 6	
E4.4		Хаягдал бохир ус цэвэрлэх	Цэвэрлэсэн нийт хаягдал бохир усны хэмжээ	20.9 мян.м3	м3/Л	Үйлдвэрийн хаягдал 20.9 мян.м3 усыг цэвэрлэх байгууламжаар цэвэрлэж төвийн шугамд нийлүүлсэн.		GRI 303, SDG 6	
E5.1	Хатуу хог хаягдал	Хог хаягдал	Нийт ялгаруулсан хог хаягдлын хэмжээ	261.6 тонн	тонн	Хог хаягдлыг эх үүсвэрээр нь дахивар, цаас, бусад гэж ангилдаг. Ялгах хогийн савыг нийт үйлдвэр, оффисын хэмжээнд дотор талбайд 34 байршилд 174 ширхэг, гадна талбайд 4 байршилд 12 ширхэг тус тус байршуулсан. "Эко орчин" ХХК-тай хог тээвэрлэлтийн гэрээ байгуулан 85.7 тн дахин боловсруулах боломжгүй хог хаягдлыг нийт 98 рейсээр тээвэрлэлт хийлгэн Морингийн давааны төвлөрсөн төв хогийн цэгт тушаасан.		GRI 306, SDG 12	
E5.2		Дахин боловсруулсан хатуу хог хаягдал	Хог хаягдлыг дахин боловсруулсан хувь	19.65%	%	2023 онд 46,065.6 кг цаасны хогийг "Агар тайж" ХХК-д, 5,334.3 кг гялгар уут, хуванцар савыг "Мульти пак" ХХК, "Өнгө нэм" ТББ-д дахин боловсруулалтад оруулсан. Нийт хог хаягдлын 19.65%-г дахин боловсруулалтад өгсөн.	Технологийн үлдэгдлийг дахин боловсруулан Cashmere Robot коллекц үйлдвэрлэх болсноор хаягдал болон байгальд хаягдахаас сэргийлдэг.	GRI 306, SDG 12	
E5.3		Хортой хог хаягдал	Хортой хог хаягдлын нийт хэмжээ (Үүнд цахилгаан хэрэгслийн хог орно)	1298 ширхэг	тонн	Химийн бодисын сав, баглаа боодол устгал хийлгэх ажлыг БОАЖЯ-ны тусгай зөвшөөрөлтэй "Элемент" ХХК-тай хамтран ажиллах гэрээний хүрээнд 1298 ширхэг хуванцар сав баглаа боодлыг байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөөс сэргийлэн мэргэжлийн байгууллагад шилжүүлсэн ажилласан.		GRI 306, SDG 12	
E6.1	Биологийн олон янз байдал	Ногоон байгууламж, төлөвлөлт	Байгаль орчны хувьд тогтвортой ашиглаж буй нийтийн эзэмшлийн талбай буюу барьсан ногоон байгууламжийн талбайн нийт талбайд эзлэх хувь	12%	%	Байгууллагын хэмжээнд 2023 онд гадаа талбайн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд 618м2 талбайд зүлэгжүүлэлтийн ажил хийж гүйцэтгэн ногоон байгууламжийн талбайг хэмжээг 12%-д хүргэсэн.		GRI 304, SDG 15	
E6.2		Зэрлэг ургамал, амьтдыг хамгаалах	Хамгаалсан төрөл зүйлийн тоо	0	Төрөл зүйлийн тоо	Байхгүй.		GRI 304, SDG 15	
E6.3		Биологийн олон янз байдалд сөргөөр нөлөөлж буй үйл ажиллагаа	Тусгай хамгаалалттай газар нутаг, биологийн олон янз байдал, соёлын үнэ цэнэ өндөртэй газар нутгийг эзэмшиж, түрээсэлсэн, удирдаж байгаа эсвэл зэргэлдээх үйл ажиллагааны талбайн нийт талбайд эзлэх хувь	0	%	Байхгүй.		SFRD, IFC Performance Standard 6	
Нийгмийн шалгуур үзүүлэлтүүд									
S1.1	Хүний нөөц	Хүний нөөцийн тогтвортой байдал	Үндсэн ажилтнуудын ажлын байрны сэлгээний хувь (тухайн онд ажлаасаа гарсан ажилтнуудын тоог ажилласан ажилтнуудын дундаж тоонд хуваах)	40%	%	Ажлын байрны сэлгээний хувь: 40%		GRI 401, SDG 8	
S1.2		Шинээр бий болгосон ажлын байр	Өмнөх оны мөн үеэс нэмэгдсэн бүтэн цагийн ажлын байрны тоо	315 ажлын байр	Тоо	Өмнөх оны мөн үетэй харьцуулахад шинээр 315 ажлын байр шинээр бий болсон бөгөөд 2023 онд нийт 1,038 ажилтан ажилд орсон байна.		GRI 401, SDG 8	
S1.3		Сургалт	Нэг ажилтанд ногдох жилийн дундаж сургалтын цаг	11.6 хүн/цаг	цаг	Нийт мэргэжлийн үр чадварын сургалт - 9248 хүн/цаг Нийт ерөнхий үр чадварын сургалт - 11252 хүн/цаг Нэг ажилтанд ногдох мэргэжлийн үр чадварын сургалт - 5.2 цаг Нэг ажилтанд ногдох ерөнхий үр чадварын сургалт - 6.4 цаг	Тогтвортой хөгжлийн сургалт болон ХАБЭА-н сургалтын цагийг MS4.1, SS2.3 хэсэгт тусад нь оруулсан учир энэ хэсэгт оруулан тооцоогүй болно.	GRI 401, SDG 8	
S2.1	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй (ХАБЭА)	ХАБЭА-н бодлого	ХАБЭА-н бодлого, журам бий юу (тусдаа бодлого журам эсвэл аль нэг журамд нэгтгэсэн)?	Тийм	1.Тийм 2.Үгүй	Гүйцэтгэх захирлын 2020.03.27-ны өдрийн А/145 тоот тушаалаар Б-ХЭМАБ-БОХ-11-03 дугаартай ХЭМАБ-БО-ны бодлогын баримт бичиг боловсруулан батлагдсан. ХЭМАБ-н хэлтсийн Т2 түвшний нийт-17 журам батлуулан байгууллагын хэмжээнд мөрдөн ажиллаж байна.		GRI 103, SDG 10	
S2.2		Осол аваар	Үйл ажиллагааны явцад гарсан осол аваарын хувь	1.66	давтамж	Говь ХК-ийн хэмжээнд 2023 онд хугацаа алдсан гэмтэл буюу үйлдвэрийн осол-1, нас баралттай осол-1, осолд дөхсөн буюу анхны тусламж авсан гэмтэл-18 бүртгэгдсэн. 2023 онд дунджаар 1600 ажилтан хугацаа алдсан гэмтэлгүй ажилласан өдөр-199, хугацаа алдсан гэмтэлгүй ажилласан цаг-2,547,200 хүн/цаг, хугацаа алдсан гэмтлийн давтамж-1.66 болно. Тоолж эхэлсэн огноо-2023.05.12-ний өдрөөс эхлэн тооцсон.	Осол аваарыг хувиар биш давтамжаар тооцдог болно.	GRI 403, SDG 3	
S2.3		ХАБЭА-н сургалт	Жилд нэг ажилтанд ногдох дундаж ХАБЭА сургалтын цаг	12.7 хүн/цаг	цаг	2023 онд 7891 ажилтанд, 207 цагийн сургалт буюу 1 ажилтанд 12.7 хүн/цаг сургалт орсон.		GRI 403, SDG 3	
S2.4		Эрүүл мэндийн хөтөлбөр	Эрүүл мэндийн үзлэг зэрэг сайн дурын эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдсан ажилчдын тоо, жилээр	Давхардсан тоогоор 6023	хүн	Эмнэлгийн анхан шатны нэгжээр давхардсан тоогоор 3251 ажилтан өдөр тутмын үзлэг үйлчилгээ авсан. 2023 оны эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх хугацаат үзлэгт хэвийн болон хэвийн бус нөхцөлд ажилладаг 1575 ажилтан хамрагдсан. Шинэ ажилтны үзлэг 1080, Ковидын түргэвчилсэн тест 117. Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх хугацаат үзлэгт хамрагдсан ажилтнуудын үзлэгийн хуудас болон Эрүүл мэндийн байгууллагаас өгөгдсөн нэгдсэн тайлан, зөвлөмжийг хэрэгжүүлэх үе шаттай 3-5 жилийн "Эрүүл мэнд" хөтөлбөр түүнд үндэслэн жил бүрийн ажилчдын Эрүүл мэндийг чанаржуулах, хэвээр хадгалах төлөвлөлт гарган ажилладаг.		GRI 403, SDG 3	
S3.1	Жендэрийн бодлого, журам	Жендэрийн бодлого, журам	Жендэрийн бодлого, журам бий юу (тусдаа бодлого журам эсвэл аль нэг журамд нэгтгэсэн)?	Тийм	1.Тийм 2.Үгүй	Ж-ХНГ-24-01 дугаартай Ажлын байрны дарамт, хүчирхийлэл, бэлгийн дарам, жендэрийн тэгш эрх, ялгаварлан гадуурхалтаас урьдчилан сэргийлэх журам 2022.03.01-ний өдрөөс хэрэгжин ажиллаж байна.		GRI 405, SDG 5	
S3.2		Ажлын байрны бэлгийн дарамтын эсрэг бодлого, журам	Бэлгийн дарамтын эсрэг бодлого, журам бий юу (тусдаа бодлого журам эсвэл аль нэг журамд нэгтгэсэн)?	Тийм	1.Тийм 2.Үгүй	Ж-ХНГ-24-01 дугаартай Ажлын байрны дарамт, хүчирхийлэл, бэлгийн дарам, жендэрийн тэгш эрх, ялгаварлан гадуурхалтаас урьдчилан сэргийлэх журам 2022.03.01-ний өдрөөс хэрэгжин ажиллаж байна.		GRI 103, SDG 5	

S3.3	Эрх тэгш байдал	Ялгаварлан гадуурхалтын эсрэг бодлого, журам	Ялгаварлан гадуурхалтын эсрэг бодлого, журам бий юу (тусдаа бодлого журам эсвэл аль нэг журамд нэгтгэсэн)?	Тийм	1.Тийм 2.Үгүй	Ж-ХНГ-24-01 дугаартай Ажлын байрны дарамт, хүчирхийлэл, бэлгийн дарам, жөндөрийн тэгш эрх, ялгаварлан гадуурхалтаас урьдчилан сэргийлэх журам 2022.03.01-ний өдрөөс хэрэгжин ажиллаж байна.	GRI 103,SDG 10
S3.4		Ажилтнуудын хүйсийн харьцаа	Нийт үндсэн ажилтнуудын тоонд эрэгтэй, эмэгтэй ажилтны эзлэх хувь	Эрэгтэй ажилтан 31% Эмэгтэй ажилтан 69%	%	Эрэгтэй ажилтан 31% Эмэгтэй ажилтан 69%	GRI 405, SDG 5
S3.5		Удирдах зөвлөлийн хүйсийн харьцаа	Удирдах зөвлөлийн гишүүдийн эрэгтэй, эмэгтэй хүйсийн харьцаа	Эрэгтэй ажилтан 67% Эмэгтэй ажилтан 33%	%	Эрэгтэй ажилтан 67% Эмэгтэй ажилтан 33%	GRI 405, SDG 5
S3.6		Гүйцэтгэх удирдлагын хүйсийн харьцаа	Гүйцэтгэх удирдлагын түвшний ажилтнуудын эрэгтэй, эмэгтэй хүйсийн харьцаа	Эрэгтэй ажилтан 38% Эмэгтэй ажилтан 62%	%	Эрэгтэй ажилтан 38% Эмэгтэй ажилтан 62%	GRI 405, SDG 5
S3.7		Дунд болон анхан шатны нэгжийн ажилтнуудын хүйсийн харьцаа	Дунд болон анхан шатны нэгжийн ажилтнуудын эрэгтэй, эмэгтэй хүйсийн харьцаа	Эрэгтэй ажилтан 31% Эмэгтэй ажилтан 69%	%	Эрэгтэй ажилтан 31% Эмэгтэй ажилтан 69%	GRI 405, SDG 5
S3.8		Жөндөрт суурилсан цалингийн зөрүү	Эрэгтэй ба эмэгтэй ажилтнуудын дундаж цалингийн харьцаа	1.044	харьцаа	2023 онд эрэгтэй ажилтны дундаж цалинг эмэгтэй ажилтны дундаж цалинд харьцуулсан харьцаа 1.044 байна. Өөрөөр хэлбэл, эрэгтэй ажилтны дундаж цалин эмэгтэй ажилтны дундаж цалингаас 4.4%-р өндөр байна.	GRI 405, SDG 5, SFRD
S4.1	Хүртээмжтэй байдал	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бодлого, журам	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан бодлого, журам бий юу (тусдаа бодлого журам эсвэл аль нэг журамд нэгтгэсэн)?	Тийм	1.Тийм 2.Үгүй	Ж-ХНГ-01-10 дугаартай Хөдөлмөрийн дотоод журманд дараах зохицуулалтуудыг оруулсан байдаг. Үүнд: 4.1.1 Иргэний ажилд авахдаа үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, иргэний харьяалал, арьс өнгө, нийгмийн гарал, шашин шүтлэг, хөрөнгө чинээ, гэрлэлтийн байдал, бэлгийн чиг хандлага, хүйсийн чиг баримжаа, хөдөлмөрийн чадвар алдалт, үзэл бодол, улс төрийн үзэл бодол, үйлдвэрчний эвлэлийн гишүүн эсэх, эрүүл мэндийн байдал, жирэмсэн болон амаржсан эсэх, илэрхийлэл, хөгжлийн бэрхшээл, гадаад төрхөөр нь шууд, эсхүл шууд бусаар ялгаварлан гадуурхах, эрхийг нь хязгаарлах, давуу байдал олгохгүй, сонирхлоор нь ялгаварлахгүй тэгш хандах бодлого баримтална. Мөн ажилд авах болон ажилтныг ажил үүрэгтэй нь холбогдолгүй асуулт асуух, мэдээлэл цуглуулахгүй ба эрүүл мэндийн үзлэгээс өөрөөр сэтгэцийн эмгэг, дархлал хомсдолын вирусын шинжилгээ хийлгүүлэхгүй байна. Компани нь хөгжлийн бэрхшээлтэй хүний болон хөгжлийн бэрхшээлтэй гэр бүлийн гишүүнээ гэртээ асарч байгаа хүний үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүн, ажил үйлчилгээг гэрээгээр байнга худалдан авах замаар хөгжлийн бэрхшээлтэй хүнд хөдөлмөр эрхлэх боломжийг олгох зарчмыг баримтална.	SDG 10
S4.2		Хөгжлийн бэрхшээлтэй ажилтнууд	Хөгжлийн бэрхшээлтэй ажилтнуудын нийт ажилтны тоонд эзлэх хувь	1%	%	Хөгжлийн бэрхшээлтэй ажилтны тоо: 19 Нийт ажилтны тоонд эзлэх хувь: 1%	SDG 10
S4.3		Оффисын хүртээмж	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй байдлаар шийдсэн оффис, байгууламжтай юу	Тийм	1.Тийм 2.Үгүй	* Компанийн байранд нэвтрэхтэй холбоотой зориулалтын шаттай * Хуулийн дагуу ажлын цагийг богиносгосон цагаар хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллуулдаг * Цалингаас тооцох шимтгэлийг хуулийн дагуу тооцон олгодог * 2023 онд үйлдвэрийн ариун цэврийн өрөөг ХБИ-д зориулснаар тохижуулсан.	SDG 10
S4.4		Торгууль	Байгаль орчны зөвшөөрөл, стандарт, дүрэм журмыг дагаж мөрдөөгүйгээс гарсан зөрчлийн тоо	0	Төгрөг	Байгаль орчны зөвшөөрөл, стандарт, дүрэм журмыг дагаж мөрдөөгүйгээс гарсан зөрчил байхгүй.	SDG 10
S5.1	Нийгмийн хариуцлага ба ил тод байдал	Оролцогч талуудын оролцооны засаглал	Оролцогч талуудтай хамтарч ажиллах талаар тусгайлсан бодлого байгаа юу?	Тийм	1.Тийм 2.Үгүй	Говь ХК-ийн "Засаглалын бодлого"-д оролцогч талуудын эрх ашгийг ханган ажиллах тухай зорилтуудыг тодорхойлон оруулсан байдаг. Мөн ТУЗ-өөс 2023 оны 4-р сард "Хөрөнгө оруулагчидтай харилцах хөтөлбөр", 11-р сард "Оролцогч талуудын хамтын ажиллагааны удирдлагын төлөвлөгөө"-г тус тус баталсан.	IFC
S5.2		Нийгмийн нөлөөллийн үнэлгээ, газар чөлөөлөлтийн бодлого журам	Танай компани нийгэмд нөлөөлөх байдлын бодлого, журамтай юу? (Үүнд газар чөлөөлөлт багтана)	Тийм	1.Тийм 2.Үгүй	Байгууллагын хэмжээнд гүйцэтгэх захирлын 2024.01.11 ны өдрийн батлагдсан НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНД, АЮУЛГҮЙ БАЙДЛЫН НӨЛӨӨЛЛИЙГ ҮНЭЛЭХ ЖУРАМ баталж мөрдөн ажиллаж байна	IFC Performance Standards
S5.3		Санал гомдлыг шийдвэрлэх бодлого/журам	Гомдол маргааныг шийдвэрлэх бодлого, механизм бий юу?	Тийм	1.Тийм 2.Үгүй	Компанийн гүйцэтгэх захирлын 2022.11.03-ны өдрийн А/473 дугаар тушаалаар батлагдсан Говь ХК-ийн Ж-3АА-28-03 дугаартай "Оролцогч талуудын өргөдөл, санал, гомдол хүлээн авах, шийдвэрлэх журам"-ыг баримтлан сар, хагас, бүтэн жилээр тайлан мэдээ гаргаж танилцуулан ажиллаж байна.	GRI 102, SDG 16
S5.4		Олон нийтэд ил тод мэдээлэх	Танай компанийн үйл ажиллагаа нөлөөлж буй иргэдэд мэдээлэл өгөх, санал хүсэлт авч, гомдол шийдвэрлэх тогтолцоо бий юу?	Тийм	1.Тийм 2.Үгүй	Компанийн гүйцэтгэх захирлын 2022.11.03-ны өдрийн А/473 дугаар тушаалаар батлагдсан Говь ХК-ийн Ж-3АА-28-03 дугаартай "Оролцогч талуудын өргөдөл, санал, гомдол хүлээн авах, шийдвэрлэх" журамын 2.1.1-д заасны дагуу оролцогч талуудын өргөдөл, санал, гомдлыг 5 сувгаар хүлээн авч байна. 1. "Говь" ХК-ийн өргөдөл, санал, гомдол хүлээн авах албан ёсны и-мэйл хаягаар Complaint@gobi.mn , 2. Утсаар /999053571/ 3. Компанийн албан ёсны цахим хуудсаар info@gobi.mn/whistleblowing 4. Албан бичгээр, 5. Тухайн хариуцсан газрын холбогдох менежер, хэлтсийн дарга, газрын захирлаар дамжин ирэх.	IFC Performance Standards
S5.5		Ажилчид/олон нийтийн санал гомдол	Ажилчид болон олон нийтээс ирсэн санал гомдлыг шийдвэрлэсэн хувь	100%	%	2023 оны байдлаар нийт 355 ш гомдол ирсний 67% нь үйлдвэрээс шалтгаалсан, 17% нь гадны нөлөөтэй буюу хэрэглээний явцад болон тээвэрлэлттэй холбоотой гомдол байсан. Дээрх санал гомдлыг 100% шийдвэрлэн ажилласан.	GRI 413, SDG 8
S5.6		Нийгмийн хариуцлагын үйл ажиллагаанд зарцуулсан хөрөнгө оруулалт	Нийгмийн хариуцлагын арга хэмжээ, хөтөлбөрт зарцуулсан хөрөнгө оруулалтын нийт орлогод эзлэх хувь	0.28%	%	2023 онд нийт 724,136,949 төгрөгийг нийгмийн хариуцлагын төсөл хөтөлбөрүүдэд зарцуулсан байна. Энэ нь нийт борлуулалтын орлогын 0.28%-г эзэлж байна.	GRI 413, SDG 8
S6.1	Тогтвортой өртгийн сүлжээний менежмент	Худалдан авалтын бодлого, журам	Танай компанид дотоодын худалдан авалт болон тогтвортой буюу байгаль орчин, нийгмийн эрсдэл боломжийг хангасан худалдан авалтын бодлого, журам бий юу (тусдаа бодлого журам эсвэл аль нэг журамд нэгтгэсэн)?	Тийм	1.Тийм 2.Үгүй	Говь ХК-ийн Ж21-ХАСХ-01-07 дугаартай "Захиалга хүлээн авах, Худалдан авах, Хүлээлгэн өгөх журам". Батлагдсан огноо 2021.11.30 Говь ХК-ийн Ж-ХАХ-145-01 дугаартай "Гэрээт гүйцэтгэгч, ханган нийлүүлэгчийн удирдлагын журам. Батлагдсан огноо 2023.11.03	GRI 204, SDG 8
S6.2		Дотоодын худалдан авалт	Дотоодын ханган нийлүүлэгчдээс авсан худалдан авалтын хувь	63%	%	Нийт харилцагч 211 байгууллагаас Дотоод харилцагч 134 буюу 62.9%.	GRI 204, SDG 8
S6.3		Тогтвортой, ногоон худалдан авалт	Нийт ханган нийлүүлэгчдийн тоонд тогтвортой буюу байгаль орчин, нийгмийн шалгуураар сонгогдсон ханган нийлүүлэгчдийн хувь	20%	%	Нийт 211 харилцагч байгууллагаас тогтвортой буюу байгаль орчин, нийгмийн шалгуураар сонгогдсон ханган нийлүүлэгчид 20% эзэлж байна.	GRI 204, SDG 8
Засаглалын шалгуур үзүүлэлтүүд							
G1.1	Авилгал болон ёс зүй	Авилга, хээл хахуулийн эсрэг бодлого журам	Авилгын эсрэг эсвэл Ёс зүйн бодлого, журам бий юу?	Тийм	1.Тийм 2.Үгүй	1. Говь ХК-ийн ТУЗ-ийн тогтоолоор 2022 оны 08 сард "Ёс Зүйн Код" /Д-ТХХ-01-02/-ыг шинэчлэн батлуулсан. 2. "Оролцогч талуудын өргөдөл, санал, гомдол хүлээн авах, шийдвэрлэх журам" /Ж-3АА-28-03/ 2022 оны 11 сард батлагдсан. Журмын дагуу үйл ажиллагаа явагдаж байна.	GRI 205, SDG 16

G2.1	Компанийн засаглал	Удирдах зөвлөлийн хараат бус байдал	Удирдах зөвлөлд хараат бус гишүүдийн суудлын хувь	44.44%	%	Төлөөлөн удирдах зөвлөлийн нийт 9 гишүүний 4 гишүүн нь хараат бус гишүүд байдаг. Хараат бус гишүүд нь дараах үндсэн үүрэгтэй: - ТУЗ, Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаа, гаргасан бодлого, шийдвэр нь компанийн эрх ашигт сөргөөр нөлөөлсөн эсэх, үйл ажиллагаа нь хууль тогтоомж, дүрэм, журамд нийцсэн эсэхэд хяналт тавих, зөрчлөөс урьдчилан сэргийлэх; - Зөрчил илэрвэл уг зөрчлийг арилгахыг холбогдох этгээдээс шаардах, шаардлагыг эс биелүүлвэл уг асуудлыг ТУЗ-д тавьж шийдвэрлүүлэх, улмаар хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулах шаардлагыг хүргүүлэх; - Компанийн үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах талаар гүйцэтгэх удирдлагаас шаардах, хэрэгжилтийг хянах, холбогдох этгээдээс шаардах; - Хувьцаа эзэмшигчдийн хуралд биечлэн оролцож, ТУЗ-ийн шийдвэрийн талаар зарчмын зөрүүтэй байр суурьтай байсан бол энэ талаар мэдээллэж, хувьцаа эзэмшигчдийн асуултанд хариулах, тодруулга хийх; - Гүйцэтгэх удирдлага, компани, хувьцаа эзэмшигчдийн ашиг сонирхол зөрчилдөх эрсдэлийг удирдаж, хяналт тавих.		GRI 102, OECD Principles of Corporate Governance, SDG 16	
G2.2		Цөөнх, жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх	Цөөнх, жижиг хувьцаа эзэмшигчдийн эрхийг хамгаалах дүрэм, журам бий юу?	Тийм	1.Тийм 2.Үгүй	2021 онд ТУЗ-өөс баталсан "Хувьцаа эзэмшигчдийн хурлын журам" мөн 2022 онд шинэчлэн баталсан "Олон нийтэд хүргэх мэдээллийн журам" байдаг. ТУЗ-өөс 2023 онд "Хөрөнгө оруулагчидтай харилцах хөтөлбөр"-ийг шинээр баталж, тус хөтөлбөрийн хүрээнд ТУЗ-ийн ажлын албанаас жилд 2-оос доошгүй удаа хувьцаа эзэмшигч нарын үйлдвэртэй танилцах аяллыг зохион байгуулж, хувьцаа эзэмшигч нарт зориулан гарын авлагыг бэлтгэн хүргэсэн. Манай компани хувьцаа эзэмшигч нарт хүргэх мэдээллийг цаг тухай бүрт хүргэн, ил тод байдлын хэрэгжилтийг ханган ажиллахаас гадна санал хүсэлтийг нь компанийн цахим хуудас, и-мэйл, утас зэрэг сувгуудаар дамжуулан хүлээн авч шуурхай хариу өгөн шийдвэрлэн ажилладаг.		GRI 102, OECD Principles of Corporate Governance, SDG 16	
G2.3		Компанийн засаглалын бодлого, журам	Компанийн засаглалын бодлого, журам бий юу?	Тийм	1.Тийм 2.Үгүй	2022 онд ТУЗ-өөс "Компанийн засаглалын бодлого" болон "Компанийн засаглалын кодексийг хэрэгжүүлэх хөтөлбөр"-ийг баталсан. Тус хөтөлбөрийн хүрээнд засаглалын бодлого дүрэм журмуудаа шат дараатай шинэчлэн баталж, мөрдөн ажиллаж байна. Мөн засаглалын түвшинд байвал зохих бодлого, дүрэм журмуудыг нэгтгэсэн "Компанийн засаглалын дүрэм журмуудын эмхэтгэл"-ийг ТУЗ-ийн ажлын албанаас бэлтгэн, агуулгыг нь тогтмол шинэчлэн ажилладаг. Энэхүү батлагдсан бодлого, дүрэм журмыг компанийн хэмжээнд хэрэгжүүлэн ажиллахаас гадна, ТУЗ болон ТУЗ-ийн дэргэдэх хороод чиг үүргийнхээ дагуу тогтмол хуралдаж, шийдвэр гарган хяналт тавьж ажилладаг.		GRI 102, OECD Principles of Corporate Governance, SDG 16	
G3.1	Комплаенс	Комплаенсын бодлого	Комплаенсын бодлого, журам бий юу?	Тийм	1.Тийм 2.Үгүй	Говь ХК-ийн Комплаенсын бодлого /Б22-ТХХ-01-01/ 2022 оны 05 сард батлагдан хэрэгжиж эхэлсэн. 2024 онд "Нийцлийн удирдлагын журам" боловсруулахаар ажиллаж байна.		GRI 102, OECD Principles of Corporate Governance, SDG 16	
G3.2		Комплаенсын хөтөлбөр	Комплаенсын хөтөлбөр, журам (ажилчдын сургалт, аудит, хяналтын систем, зөрчлийн талаар мэдээлэх, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх удирдамж, хориг гэх мэт) бий юу?	Тийм	1.Тийм 2.Үгүй	1. Шүгэл үлээх систем 2022 оны 11 сард ашиглалтад оров. 2. Говь ХК-ийн Ёс зүйн хороо 2022 оны 11 сард байгуулагдан шүгэл үлээх системээр ирсэн зөрчлийг шийдвэрлэн ажиллаж байна. 3. Говь ХК-ийн Шүгэл үлээх тогтолцооны үйл ажиллагааны журам 2023 оны 08 сард шинэчлэгдэн батлагдав. /Ж-ТХХ-110-02/ Журмын дагуу үйл ажиллагаа явагдаж байна. 5. Говь ХК-ийн Ёс зүйн кодыг хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих "Ёс зүйн кодын хэрэгжилтийг зохицуулах журам" /Ж-ТХХ-143-01/ 2023 оны 08 сард батлагдав. Журмын дагуу үйл ажиллагаа явагдаж байна. 6. Ёс зүйн код болон холбогдох журмууд таниулах, ойлголт өгөх, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд нийт ажилтны сургалт зохион байгуулав. 7. Говь ХК-ийн нийт газар, хэлтсийг хамруулан тэдгээрийг төлөөлөх Ёс зүйн хорооны нээлттэй сонгуулийн зарчмаар шинэчлэгдсэн бүрэлдэхүүн томилогдов.		GRI 102, OECD Principles of Corporate Governance, SDG 16	
Нэмэлт салбарын шалгуур үзүүлэлтүүд (Танай компанид хамаарах салбарын асуултуудыг бөглөнө үү)									
FS1	Санхүүгийн үйлчилгээ	Санхүүгийн хүртээмж	Санхүүгийн мэдлэг дээшлүүлэх болон санхүүгийн хэрэглэгчийг хамгаалах санаачилга, арга хэмжээнд оролцсон хүмүүсийн тоо, жилээр	703	хүн	Санхүүгийн боловсролд зориулж "Хуримтлалтай баялаг бүтээгч" арга хэмжээг нийт ажилтнуудад зориулан 3 удаагийн өдөрлөгийг зохион байгуулж нийт 210 ажилтанд мэдээлэл өгсөн бөгөөд үүнээс 35 ажилтан шууд үйлчилгээ хүлээн авч 18 ажилтанд хадгаламжийн данс нээлгэсэн. "Хувьцааны хуримлал" сургалт: 5 удаагийн 8 цагийн сургалтад 243 ажилтныг хамруулсан бол онлайнгаар 250 гаруй ажилтанд хүргэсэн байна.		SDG 1	
FS2		БОНЗ-ын эрсдэлийн менежмент	БОНЗ-ын эрсдэлийн шалгуур болон хориотой үйл ажиллагааны жагсаалтаар үнэлсэн гүйлгээний хувь	n/a	%		Банк санхүүгийн байгууллагын	Mongolian Sustainable Finance Principles	
FS3		Тогтвортой санхүүжилт	Нийт зээлийн багцад эзлэх ногоон/ТХЗ таксономийн ангилалд нийцсэн ногоон/тогтвортой зээлийн эзлэх хувь	16.4%	%		Өөрсдийн авсан зээлийн багцад эзлэх хувиар илэрхийлэв.	SDG 13, Mongolia Green Taxonomy	
A1	Хөдөө аж ахуй & хүнсний үйлдвэрлэл	Устгалын бодис	Устгалын бодис ашиглах бодлого журам бий юу?	Үгүй	1.Тийм 2.Үгүй		Устгалын бодис ашигладаггүй тул устгалын бодис ашиглах бодлого журам байхгүй	GRI 403, SDG 12	
A2		Тогтвортой газар, бэлчээр	MNS 6891:2020, Хариуцлагатай нүүдэлчин стандарт эсвэл түүнтэй ижил төстэй тогтвортой бэлчээрийн стандартыг хэрэгжүүлж чадсан бэлчээрийн талбайн хувь	n/a	%			SDG 12	
A3		Буцаан татан авсан бараа бүтээгдэхүүн	Хүнсний чанар, аюулгүй байдлыг хангаагүй буцаагдсан эсвэл худалдах боломжгүй болсон бүтээгдэхүүний хувь	n/a	%			GRI 416, SDG 12	

T1	Текстиль	Тогтвортой мал аж ахуй	MNS 6891:2020, Хариуцлагатай нүүдэлчин стандарт эсвэл түүнтэй ижил төстэй тогтвортой бэлчээрийн стандартыг нэвтрүүлсэн малын тоо, бэлчээрийн эзлэх хувь	106 малчин	но. & %	"Тогтвортой ноолуур, гурван талт хамтарсан төсөл" Баянхонгор аймгийн Жинст сум, Хөвсгөл аймаг, Их Уул сумдад үйлдвэрлэл-шинжлэх ухаан-малчид хоорондын уялдаа холбоог бэхжүүлэх, тогтвортой түүхий эдийн талаар малчдын мэдлэгийг нэмэгдүүлэх, нэг малаас гарах түүхий эдийн ашиг шимийг сайжруулах замаар малчин өрхийн орлогыг дэмжих зорилго бүхий төслийг 3 дахь жилдээ ХААИС, болон 106 малчидтай хамтран хэрэгжүүлж байна. Ингэснээр тогтвортой бэлчээрийн стандартыг хангах ажилд хувь нэмэрээ оруулж байна.	Бэлчээрийн эзлэх хувийг тодорхойлох боломжгүй тул төсөлд хамрагдсан малчны тоог оруулав.	GRI 403, SDG 12
T2		Тогтвортой аргаар үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн	Текстилийн тогтвортой үйлдвэрлэлийн стандартын (MNS 6926:2021) дагуу үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний тоо, эзлэх хувь	1,040,030 100%	но. & %	2023 оны 12 сард Текстилийн тогтвортой үйлдвэрлэлийн стандартын (MNS 6926:2021) магадлан аудитад амжилттай оролцсон. 2023 онд нийт 1,040,030 ширхэг бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн.		GRI 416, SDG 12
MA1	Боловсруулах	Химийн бодисын менежмент	Химийн бодис болон хортой материалыг зохистой хадгалах бодлого, журам	Тийм	1.Тийм 2.Үгүй	Химийн хортой болон аюултай бодис захиалах, худалдан авах, тээвэрлэх, хадгалах, ашиглах, устгах журам шинэчлэн батлуулсан.		GRI 403, SDG 12
MA2		Дахин боловсруулсан материал	Дахин боловсруулсан материал, орц ашиглалтын хувь	11.30%	%	Нийт 705,461,390 өртөг бүхий дахин боловсруулсан материалаар хийсэн туслах материал худалдан авсан. Энэ нь нийт туслах материалын худалдан авалтын 11.3%-г эзэлж байна. Мөн үйлдвэрлэлийн явцад үүссэн технологийн үлдэгдлийг хаягдал болохоос сэргийлэн, дахин боловсруулж Cashmere Reborn коллекцийг үйлдвэрлэж эхэлсэн бөгөөд 2023 онд 4885 бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн нь нийт үйлдвэрлэлийн 0.47%-г эзэлж байна.		SDG 12
MA3		Ногоон шошго, гэрчилгээжүүлэлт	Эко буюу ногоон шошго, гэрчилгээтэй бүтээгдэхүүний эзлэх хувь	0%	%	1. Швейцарь улсын Цюрих хотод төвтэй OEKO-TEKC байгууллагын "STANDARD 100 by OEKO-TEX" стандартын шаардлагыг хангаж олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн чанарын гэрчилгээг 4 дахь жилдээ Ээрмэл утсанд авсан. 2. Англи улсад төвтэй "Тогтвортой ноос ноолуурын эвсэл" / SFA байгууллагын "Цэвэр ноолуур боловсруулах зохистой дадал"-ын тохирлын үнэлгээнд 3 дахь удаагаа амжилттай хамрагдаж "Алтан батламжлал" гардан авсан. 3. Ямааны ноолууран "Н-1, 02, 03, 57, 1000 кодтой утас нь химийн будаггүй, цайруулалтгүй ба эдгээр утсаар хийгдсэн сүлжмэл, нэхмэл, оёмол бэлэн бүтээгдэхүүн нь үйлдвэрлэлийн менежмент, чанарын үзүүлэлтүүд органик хөдөө аж ахуй гаралтай бүтээгдэхүүнд тавигдах шаардлагыг ханган "Органик бүтээгдэхүүн" гэрчилгээгээ дахин сунган ажиллаж байна. 4. ISO 9001:2015 Чанарын удирдлагын тогтолцооны стандартын баталгаажуулалт авсан бөгөөд үүнтэй холбогдуулан бүтээгдэхүүний чанар өсч, гологдол болон дахин хийлтийн хувь багассан.	Эцсийн бүтээгдэхүүнд OEKO-TEKC 100 стандартын гэрчилгээжүүлэлт хийхээр ажиллаж байна	GRI 417, SDG 12
M11	Уул уурхай	Нөхөн сэргээлт	Нийт ашиглалтын зориулалттай газартай харьцуулахад нөхөн сэргээлт хийсэн газрын талбайн хувь	12%	%	Байгууллагын ногоон байгууламжийн талбайг нэмэгдүүлэхээр 618м2 талбайд зүлэгжүүлэлт хийж Хайлаас мод 3000 ширхэгийг ургамлан хашлагын зориулалтаар тарьсан.		SDG 15
M12		Торгууль	Байгаль орчны зөвшөөрөл, стандарт, дүрэм журмыг дагаж мөрдөөгүйгээс гарсан зөрчлийн тоо	Байхгүй	Зөрчлийн тоо	Байгаль орчны зөвшөөрөл, стандарт, дүрэм журмыг дагаж мөрдөөгүйгээс гарсан зөрчил байхгүй.		GRI 307, SDG 15
M13		Нүүлгэн шилжүүлэлт	Эдийн засгийн шилжилт хөдөлгөөн, нүүлгэлтэд хамрагдсан иргэдийн тоо	n/a	Хүн	Байхгүй.		GRI 203, SDG 1
CO1	Барилга	Ногоон барилгын шошго/гэрчилгээ	Ногоон барилгын шошго/гэрчилгээ авсан барилгын төслүүдийн хувь	n/a	%			GRI 417, SDG 12
CO2		Хүртээмжтэй байдал	Монгол Улсын хэрэгжиж буй хүртээмжтэй байдлын тухай хууль тогтоомжид нийцсэн барилгын төслүүдийн хувь (үүнд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хүртээмжийг мөн харгалзана)	n/a	%			SDG 10
CO3		Ногоон байгууламж, талбай	Монгол Улсын ногоон байгууламж, нийтийн талбайн хууль тогтоомжид нийцсэн барилгын төслүүдийн хувь	n/a	%			GRI 304, SDG 15




БОНЗ-ын тайланг хянасан:

Тэргүүн дэд захирал

Тогтвортой хөгжлийн хэлтсийн дарга

БОНЗ-ын тайланг боловсруулсан:

Тогтвортой хөгжлийн ахлах менежер

 Б.Энхмандах
 З.Ивгэл
 З.Ариунзул